

## ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**М. ЗЭНЭЭ, ӨВӨР МОНГОЛЫН АРДЫН  
АМАН ЗОХИОЛ. УБ. 1981 ОН****(Шүүмж)**

Нийгмийн хөгжлийн түүхийн аль ч үед аливаа ард түмэн бодит байдлын тусгал, хүсэл эрмэлзлэлийнхээ илэрхийлэл, хөдөлмөр тэмцлийнхээ дуу уриа болсон урлаг соёлыг бүтээсээр ирсэн түүхтэй. Эдгээр урлаг, соёлын дотор ардын аман зохиол ялангуяа монголчуудын дунд ардын дуу бүр ч онцгой байр суурь эзэлдэг.

Харийн болоод дотоодын дарлагчдын харгислал, түрэмгийлэлд олон зуун жилээр нухлагдан зовж байсан аль ч орны ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнол сайн сайхан амьдралын төлөө тэмцлийн олон хэлбэрийг ашигладаг байв. Энэ тэмцлийн нэг өвөрмөц хэлбэр нь ардын аман зохиол юм.

Ангит нийгмийн үе дэх хоёр соёлын тухай Лениний сургаал ёсоор мөлжигч ангийн эрх ашгийг хамгаалсан харгис соёл байхаас гадна хөдөлмөрчин олон түмний хүсэл эрмэлзлэлийг тусгаж тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн ардчилсан соёл байдаг тул аливаа үндэсний соёл хэзээ ч нэгдмэл байх бололцоогүй ажээ.

Антагонист нийгмийн үед зайлшгүй хоёр соёл оршдог тухай Ленин зааж хэлэхдээ: «...үндэстний соёл бүхэнд хэдийгээр хөгжөөгүй ч гэсэн ардчилсан ба социалист соёлын цогцос байдаг бөгөөд учир нь үндэстэн бүрд хөдөлмөрчин мөлжигдсэн олон түмэн гэж байдаг болохлоор тэдний аж төрж байгаа нөхцөл нь ардчилсан социалист үзэл суртлыг зайлшгүй төрүүлдэг юм»<sup>1</sup> гэжээ. Энэ хоёр соёлын ангиудын харьцаа үзэл сурталд хэрхэн нөлөөлж, нийгэмд ямар үүрэг роль гүйцэтгэж ирсэн ба ард түмэнд хэр ойр дөт байснаараа үнэ цэнэ нь илэрхийлэгддэг. Мөлжигч ангийн соёл дарангуйллын зэвсэг болж байдаг бол мөлжигдөгч ангийн соёл хэзээ ямагт ард түмэнд ойр байж, тэдний ажил амьдрал, хүсэл эрмэлзлэлийн жигүүр болон урам зоригийг нь бадрааж ард түмэнтэй хамт амьдран, тэдний үзэл санааны өсөлт хөгжилтийн тусгал болон уламжлагдан шинэчлэгдэж байдаг. Үүний тодорхой жишээ бол ард түмний дунд үе дамжин хэлцэгдэж ирсэн ардын аман зохиол тухайлбал ардын дуу, зүйр цэцэн үг явган үлгэр зэрэг аман зохиолын баялаг өв уламжлалтай төрлүүд юм. Ардын аман зохиолын улиран уламжлагдан амьдарч чаддаг үнэ цэнийн тухай К. Маркс хэдэхдээ: «Үлгэр туульс нь нийгмийн хөгжлийн тодорхой нэгэн хэлбэртэй холбоотой гэдгийг ойлгох хэцүү бус... харин урлаг туульсыг одоо хүртэл бид уран сайхны хувьд таашаан хэрэглэж тэр нь зарим талаар бидний баримтлах хэм хэмжээ цаглашгүй үлгэр дууриал болсоор буй нь гайхалтай юм»<sup>2</sup> гэсэн нь ардын аман зохиол нь

1. В. И. Ленин, Зохиолууд, 20-р бот, УБ, 1966, 8-р тал.

2. К. Маркс. Ф. Энгельс. Зохиолууд, 12-р боть. 736—738-р тал.

шинэ цагийн урлаг, утга зохиолын урьдач нөхцөлийг бүрдүүлж түүний хөгжих үржил шимт хөрс болж өгдөгийг сургаж үнэ цэнийг тодорхойлсон хэрэг юм.

Олон үеийн турш ам дамжин хэлэгдэж ард түмний урын сангийн манлай болж ард түмний оюун ухаанаар шүүгдэн тунгаагдаж цэвэршсэн алт мэт үнэтэй ардын аман зохиол монголын ард түмний дунд маш арвин билээ.

Нийт монголчуудын дунд өргөн дэлгэр тархсан ардын аман зохиолын арвин сангаас өвөр монголчуудын амьдрал тэмцлийн түүхийг тодруулахад нэмэр хандив болохуйц аман зохиолын зарим төрлөөс сонголт хийж тухайн цаг үеийн бодит үйл явдалтай холбон тайлбарласан «Өвөр Монголын ардын аман зохиол» ном саяхан хэвлэгдэн гарлаа. Энэ номыг ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан М. Зэнээ эмхэтгэн цэгцэлж, оршил, судалгааны тайлбар хийж хэвлүүлжээ.

Уг ном удиртгал, үндсэн хоёр бүлэг, судалгааны үнэлэлт дүгнэлтэйн гадна зүйл тус бүрд тайлбар хэсгүүдтэй номын эцэст орос товчлол, төгсгөл үг, ном зүйн хэлхээсээс бүтэж байна.

Номд орсон ардын аман зохиолын гол хэсгийг ардын дуунд зориулжээ. Ардын дууг дотор нь:

1. Харийн дарлалын эсрэг
2. Нийгмийн дарлалын эсрэг

3. Хувьсгалын сэдэвтэй гэсэн гурван хэсэгт хуваагаад, харийн дарлалын эсрэг утга санаатай ардын дууг манж, хятадын дарлалын үе, японы эзлэлтийн үе гэж гурав хувааж ардын дуунд түүхийн он цагийн үүднээс ангилал тогтоосон нь дуу гарсан тухайн үеийн түүхэн нөхцөлийг улам тодруулж уншигчдын сонирхол татахаар барахгүй орчин үеийн хувьсгалт дууны үр хөврөл ардын дуунд байдгийг нотлох боломж олгож байна.

Нийт монголын ард түмний аман зохиол, түүний дотор Өвөр Монголд холбогдолтой ардын аман зохиолын үнэт дээжээс цуглуулан, тэдгээрт түүхэн үүднээс шинжилгээ судалгаа хийж, тухайн цаг уед ардын аман зохиол нь ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл, олон түмний үзэл санаанд хэрхэн нөлөөлж байсныг өвөр монголын жишээн дээр авч үзсэн энэ ном манайд аман зохиолын энэ чиглэлээр урьд өмнө судлагдаж байгаагүй шинэ зүйл болов.

Өгүүлэн буй бүтээл өвөр монголын ард түмний эрх чөлөө, сайн сайхан амьдралын төлөө тэмцлийн зориг хүслийн илэрхийлэл болсон ардын аман зохиолоор дамжуулан манж, хятадын эзлэн түрэмгийлэгч уламжлалт бодлоготой уншигчдыг танилцуулаад зогсохгүй тэдний эзлэн түрэмгийлэх, уусган хятадчилах харгис дээрэнгүй бодлогын түүхэн үнэнийг уран сайхнаар харуулсан баримт нотолгоо сайтай ардын дуу, аман зохиолыг хамарчээ.

Ардын дуунд ард түмнийг эрх чөлөөний тэмцэлд зоригжуулагч нөлөө үзүүлж тэднийг хэрхэн идэвхжүүлж байсныг жишээ баримтаар тайлбарласан байна.

Энд өгүүлэгдэж байгаа ардын дуунуудад өвөр монголын ард түмний тэмцэл хөдөлгөөн өрнөж, харийн болон нийгмийн дарлалын эсрэг шийдвэртэй тэмцэж байсан Тогтох, Гаадаа мээрэн, «Шинэ лам» буюу Өлзийжаргалын тухай бодит хүмүүсийн үйл амьдралтай холбогдолтой дуу цөөнгүй бий. Хятадын колоничлогчдод бэлчээр нутгаа худалдсан харгис феодалуудын эсрэг тэмцэж байсан Өвөр Монголын Жирэмийн чуулганы Горлосын өмнөт хошууны тайж Тогтохын тухай дуунд;

Агт морио уяаад гарахдаа  
Алт мөнгө олж ашгийг бодсонгүй ээ хө  
Ар өвөр хошуу нутгаа хамгаалахын төлөө  
Арван зургаан яаманд хүрсэн дээрэм нэртэй болов хө  
гэх буюу,

Өшөөтөн дайсан Япон улс  
Өөрийн нутгийг довтлоход хө  
Үндэсний баатар Тогтох  
Угтан гараад эсэргүүцсэн юм хө гэж Тогтохын ус нутгаа хамгаалж боссон эх оронч  
үзлийг илэрхийлжээ. Мөн хятадын газрын эздээс малчин, тариачин ардын газар тариаг  
булаан дээрэмдэж байсныг эсэргүүцэн боссон ардын бослогын удирдагч Жирэмийн  
чуулганы Дархан хошууны «Гаадаа мээрэний» дуунд;

Аавын төрсөн нутаг усаа  
Арга мэхтэй Хятадад булаагдвал  
Аж төрдөг манай монголын  
Ард олон яах болж байна гэж эх орноо хамгаалж, ард түмэнд сануулсан аястайгаас  
гадна;

Хамгийг мэдэх ван ноён  
Харийн ноёнд бөхөлзөж  
Хайран нутгаа худалдсан нь  
Хайран болоод жигшмээр гэж урвагч баяд ноёдыг үзэн ядаж тэднээс газар нутгаа  
өмгөөлөн хамгаалж тэмцэх хэрэгтэйг илт уриалсан байна. Энэ мэт олон жишээг иш татаж  
болно.

XVII зууны эхэнд манжийн байлдан дагуулагчдад хамгийн түрүүн эзлэгдсэн өвөр  
монголчууд манжаас тогтоосон цэргийн дарангуйллын захиргаанаас 18-60 насны  
эрэгтэйчүүдийг цэрэгт бүртгэн гурван эр тутмаас нэгийг цэрэгт дайчилж, үндэсний эх  
оронч үзэлтнийг хатуу хяналтанд авч байсныг эсэргүүцсэн тэмцэл хөдөлгөөн өрнүүлж тэр  
нь үндэсний эрх чөлөөгөө олох тэмцэл болон өргөжиж ирснийг тусгасан «Алгирмаа»  
«Данаабал» «Алтан сан» зэрэг дуунууд зохиогджээ. Энэ дуунуудыг нэгэн ёсоор түүхэн  
дуунууд гэж үзэж болох мэт.

Монгол даяар өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд өвөр монголын  
ард түмэн манжийн ноёрхлоос салсан боловч манжийн дараах хятадын засгийн газар  
Өвөр Монгол төдийгүй нийт монголын үндэсний эрх чөлөөний тэмцэл хөдөлгөөнийг  
дарахад боломжтой бүхнийг хийж хүчээр түрэмгийлэн хятадчилах харгис бодлогыг  
үргэлжлүүлэн явуулж тэр нь монголчуудын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч байсан нь  
дуунуудаас тодорхой байна. Энд манж хятадын дарлалын үеийн ардын дуунд  
дугуйлангийн хөдөлгөөнтэй холбоотой «Шинэ лам», «Гоминьданы харгислал..» зэргээс  
гадна либерал хөрөнгөтний төлөөлөгч Юань Шикайн ерөнхий сайдаар томилогдсоныг  
эсэргүүцсэн олон дуу тэр үеийн түүхэн үйл явдлын гэрч болон үлджээ.

Хятадын шунахай худалдаачин, мөнгө хүүлэгч, цэргийн харгис эрхтнүүд, өвөр  
монголын эрх чөлөө тусгаар тогтнолд дайсагнан газар шороог дээрэмдэн авах, малын  
бэлчээрийг хагалбарлан тариалах зэргээр нутгийн ард олныг элдэв арга замаар дарлан  
мөлжиж байсныг илчилсэн дуу номонд зонхилох байр эзэлж байна.

Мөн энд 1920-иод оны сүүлчээр империалист Япон Дорнод Азийг эзлэн түрэмгийлж  
улмаар 1932 онд Манжуурыг, 1933 онд Өвөр Монголын дорнод хэсгийг эзлээд тоглоомын  
Манжчжоу-го улсыг байгуулсан үеийн үйл амьдрал ч гэсэн ардын дуунд тусгагдсаныг уг  
номд тухайн үеийн дуунуудаар баталж өгсөн юм.

Үндэсний ба нийгмийн дарлалыг эсэргүүцсэн «Саранбуу», «Данаахуар», «Ванлий», «Жанамааа» зэрэг олон дууг оруулж эдгээр дуунд ард түмэн өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалж, дарлагч ангийн харгис мөн чанар, шалиг завхай байдал, авилагч муу санааг илэрхийлж хуучин нийгмийн байр суурь ганхаж ялзран доройтож буйг илчилсэн байна.

Мөн номд ардын дуунаас гадна үлгэр, зүйр цэцэн үг зэрэг аман зохиолын бусад төрлийг хамран оруулж өвөр монголын ардын аман зохиолын шинж чанарыг аль болох олон талаас нь үзүүлэхийг зорьжээ.

Өвөр Монголын аман зохиолд ийнхүү урьдчилсан судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгч эмхтгэн гаргаснаараа монголчуудын түүх, соёлыг хэзээнээс хятадын түүх соёлын хавсарга мэтээр улиг домог болгодог маоист түүхчдийн харгис номлолд энэ ном энгийн тэр тусмаа өвөрмөц хийгээд хүчтэй няцаалт болж байна. Өвөр Монголын аман зохиолын өвөрмөц арвин сан, түүний хөгжиж ирсэн түүх үүнийг гэрчлээд зогсохгүй харин ч өвөр монголын аман зохиол нь хятадын болоод гадаадын түрэмгийлэгчдийн эсрэг ард түмний эрх ашгийг хамгаалан тэмцсэн олон үеийн шургуу тэмцэлд нэг хэлбэр нь болсоор ирсний бас нэг нотолгоо мөнийг эдгээр зохиолоор жишээлж болно.

Эцэст тэмдэглэхэд төгсгөл хэсэгт оруулсан өвөр монголын аман яруу найргийн толгой, сүүл холболт уран давталт зэрэг шүлэг дууны хийц маягийн талаар өгүүлсэн нь монголчуудын шүлэг дуунд их тохиолддог урьд өмнө олонтоо гарсан мэдээж юмыг давтсан мэт. М. Зэнээ төгсгөлийн үгэндээ «Өвөр Монголын аман зохиолд байгаа аман зохиолын төрөл зүйл шүлэглэл дүрслэлийн олон аргууд цөм монгол аман зохиолд байдаг нийтлэг шинжүүд болох нь батлагдаж байна» гэжээ. Энэ нь монгол аман зохиолын сан нийтлэг шинж чанартай болохыг нотолж байяа.

«Нийгмийн дарлалыг эсэргүүцсэн аман зохиолын бусад төрлүүд» гэдэг П бүлэгт орсон үлгэр зүйр цэцэн үг нь Өвөр Монголд төдийгүй Халх, Баруун монголын ард түмний дунд нийтлэг тарж, ам дамжин өргөн яригддаг үлгэр зүйр цэцэн үг олонтоо тааралдаж байгаа нь нийт монголчуудын аман зохиолын урын сангаас салангад авч үзэхийн аргагүй мэт санагдана.

«Эргэлдэй, «Бодь цагаан гөрөөс» зэрэг нь ардын үлгэр гэхэд эртний үлгэрийн хэв шинж багатай, харин шинэ цагийн үлгэр хэлбэртэй юм. Эдгээр зүйлийг хойш хойшдынхоо бүтээлд анхааран үзэж судалгаа шинжилгээгээ улам гүнзгийрүүлээсэй гэсэн сэтгэгдэл аяндаа төрж байна.

Өвөр Монголын Аман зохиолын тухай М. Зэнээгийн энэ ном багш сурган хүмүүжүүлэгч, ардын аман зохиол судлагч, өргөн олон уншигчдын анхаарал сонирхол татсан чухал бүтээл болжээ.

**Д. Самбалхүндэв.**